



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/014/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 99125777 Цахим хаяг: azzaya@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.25 № 277
танай _____-ны № _____-т

ЗЭРЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БААТАРБИЛЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт баталсан "Орон нутгийн сангийн үйл ажиллагааны журам", Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10 дугаар зүйлийн 10.1, дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад ороогүй, сумын хог цэвэрлэж, булаах ажилд 7,877.8 мянган төгрөгийг батлуулахгүйгээр зарцуулсан,

84 26050679

- ✓ Гүйцэтгэлийн баталгаа гаргаж ирүүлээгүй байхад гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд төлбөрийн харьцааг 70/30 хувиар олгохоор тусган, урьдчилгаа төлбөрт 104,422.2 мянган төгрөг олгосон,
- ✓ “Зэрэг хүчтэн хөтөлбөр”-ийг спортын 14 төрлөөр хэрэгжүүлэхээр баталсан боловч нийт санхүүжилтийн 85 хувь буюу 35,000.0 мянган төгрөгийг зарцуулж, хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийг үнэлээгүй,
- ✓ Сум хөгжүүлэх сангийн зээлийн насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй 28,800.1 мянган төгрөг,
- ✓ Зэрэг Шим Ус ОНӨААТҮГ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй, хууль, журмаар зөвшөөрөгдөөгүй орон нутгийн нэмэгдлийг олгосон зөрчлүүд байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Зэрэг сум нь 2025 оны байдлаар 3272 хүн амтай, 244 төрийн албан хаагчтай, 875 өрхтэй, 553 малчин өрхтэй, 149 мал бүхий өрх, малчинтай, жилийн эцсийн мал тооллогоор 204.1 мянган толгой мал тоолуулжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Зэрэг сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 778,067.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 71,184.5 мянган төгрөг буюу 110.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

Бусад асуудлын хэсэг

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт үндсэн 8 хөтөлбөрийн хүрээнд 25 дэд бүлгийн 192 заалтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн биелэлтийг 70.2 хувиар дүгнүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	935,689.05	950,607.05
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	495,221.38	485,356.18
3	1.1.3 АВЛАГА	284,668.57	276,334.92
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	117,319.1	145,915.95
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	38,480	43,000
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,510,245.26	9,542,848.15
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,510,245.26	9,542,848.15
8	1.2.2.02 Биет хөрөнгө	8,503,808.46	9,536,411.36
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	6,436.79	6,436.79
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	9,445,934.3	10,493,455.2
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,033.57	38,186.33
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,033.57	38,186.33
13	2.1.1.03 Өглөг	30,033.57	38,186.33
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,415,900.73	10,455,268.87
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	9,415,900.73	10,455,268.87
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	494,395.72	494,395.72
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	8,835,932.31	9,881,917.15
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,572.71	78,956
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	9,445,934.3	10,493,455.2

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,435,131.86	4,850,387.24
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	728,848.25	814,216.83
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	661,692.45	676,406.01
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	690,652.98	722,941.7
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-28,960.53	-46,535.69
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	13,593.95	9,981.31
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	53,561.86	127,829.51
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	707,272.58	4,036,170.41
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,782,666.29
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,999,011.04	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,471,484.71	3,784,275.11
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	3,220,617.24	3,784,275.11

13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,136,353.51	3,698,646.37
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,480.3	929,268.69
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,174.4	125,390
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	533,419.42	685,209.39
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	498,542.89	807,822.9
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	480.67	0.0
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	9,668.2	10,371.2
20	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	9,385.5	5,360
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	710,367.25	160,354.36
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	479,834.89	974,869.83
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,263.73	85,628.74
24	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	250,867.47	0
25	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	963,647.16	1,066,112.13
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	963,647.16	1,066,112.13

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,360,094.06	3,660,268.3
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	728,848.25	814,216.83
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	661,692.45	676,406.01
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-28,960.53	-46,535.69
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	13,593.95	9,981.31
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	53,561.86	127,829.51
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	14,834.3	27,987.69
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	3,827.95	8,364.92
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	34,899.61	91,476.9
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	649,894.27	2,846,051.46
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	649,894.27	778,688.78
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,782,666.29
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	284,696.4
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,981,351.54	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,041,577.23	2,836,498.77
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	3,041,577.23	2,836,498.77
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,956,968.5	2,750,870.03
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,050,544.15	1,293,591.75
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,556.7	124,501.1

20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	777,500.26	851,831.68
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	47,495.39	83,111.61
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	480.67	0.0
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	14,796.8	10,899.9
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	9,385.5	5,360
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	784,983.61	311,589.4
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	142,225.42	69,984.6
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,608.73	85,628.74
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,318,516.84	823,769.52
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,126,730.43	783,634.72
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,126,730.43	783,634.72
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,126,730.43	783,634.72
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,126,730.43	-783,634.72
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	50,000
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-50,000
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	191,786.41	-9,865.19
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	303,434.97	495,221.38
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	495,221.38	485,356.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,453,112.63	8,453,112.63
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-859.06	-859.06
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,452,253.58	8,452,253.58
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	963,647.16	963,647.16
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,415,900.73	9,415,900.73
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	9,415,900.73	9,415,900.73
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-20,127.3	-20,127.3
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,395,773.44	9,395,773.44
9	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-6,616.7	-6,616.7
10	1.7 Тайлант үеийн үр дүн	1,066,112.13	1,066,112.13
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,455,268.87	10,455,268.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,622,855.4	2,455,406.86
2	3.1.01.1.1 Татварын орлого	699,778.3	814,216.83
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	551,493.8	676,406.01
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	598,029.5	722,941.7
5	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-46,535.7	-46,535.69
16	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-46,535.7	-46,535.69
7	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	16,363.0	9,981.31
8	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	131,921.5	127,829.51
9	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	27,820.0	27,987.69
10	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	6,086.5	8,364.92
11	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	98,015.0	91,476.9
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,582,373.3	1,641,190.03
13	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	37,295.8	95,502.83
14	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,260,381.1	1,260,990.8
15	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,260,381.1	1,260,990.8
16	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	284,696.4	284,696.4
17	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	315,492.2	2,445,976.53
18	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	-210,672.0	2,062,337.21
19	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,094,657.6	1,988,925.59
20	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	996,008.9	930,157.59
21	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	124,501.1	124,501.1
22	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	693,422.3	689,552.61
23	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	24,673.1	19,258.93
24	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.2	0.0
25	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	14,481.9	10,899.9
26	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	11,274.8	5,360
27	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	166,198.8	148,430.85
28	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	63,413.5	60,764.6
29	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-2,305,329.6	73,411.62
30	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	403,874.2	333,639.32

31	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	122,290.0	50,000.0
32	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,966,659.4	-9,430.33
33	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	436,029.37
34	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	435,993.08

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	577,925.5
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	577,925.5
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	577,925.5
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	577,925.5
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	577,925.5
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	576,341.6
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,583.9
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	575,175.0
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	68,929.6
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,929.6
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	936.2
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	936.2
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,773.4
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,773.4
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	9,220.0
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	9,220.0
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	506,245.4
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	506,245.4
220001	1.1.1.2.2.1.1 Барилга байгууламж	506,245.4
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,750.5
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,750.5)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,750.5)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 219,513.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 38,329.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- Санхүүгийн тайланд орлого зарлагыг зөрүүтэй тусгасан 34,186.8 мянган төгрөг,
- ЗДТГ-т тоног төхөөрөмж нийлүүлсэн ажлын чанарын баталгааны үлдэгдлийг өр төлбөрт тусгаагүй 2,126.0 мянган төгрөг

ХХС-ийн тайланд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант оны хүүгийн авлага зөрүүтэй илэрхийлсэн 2,017.1 мянган төгрөг

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 181,183.7 мянган төгрөгийн алдаа илэрсний материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 67,033.8 мянган төгрөгөөс их байгаа тул нөлөөллийн дүнг тооцон “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 181,183.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 181,183.7 мянган төгрөгийн 6 зөвлөмж бичлээ.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Зөвлөмж

3.1.1 ОНХС-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний жагсаалтад ороогүй сумын хог отволдох ажилд сангийн хөрөнгө 7,877.8 мянган төгрөг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 60.3.6. “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.7.5. “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль, ОНХС-ын үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, сумын ИТХ-аар хэлэлцэн батлагдаагүй ТАХ-г санхүүжүүлэхгүй байх.

3.1.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэлийн баталгаа гаргаж ирүүлээгүй байхад гүйцэтгэгчтэй байгуулах гэрээнд төлбөрийн харьцааг 70/30 хувиар хийж урьдчилгаа төлбөр олгосон. Гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй 104,422.2 мянган төгрөгийг урьдчилгаанд олгосон байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43.1. “Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө”, 43.3. “Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43 дугаар зүйлийг мөрдөн ажиллах, тендерийн баталгаа гаргаж ирүүлээгүй тохиолдолд урьдчилгаа санхүүжилт олгохгүй байх.

3.1.3 ОНХС-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөтөлбөр арга хэмжээний зардлыг бөөн дүнгээр баталсан байна. Тухайлбал: “Зэрэг хүчтэн хөтөлбөр”-ийг спортын 14 төрлөөр баталсан боловч нийт санхүүжилтийн 85 хувийг бөхийн төрөлд зарцуулсан нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.4.1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хууль, журмын дагуу боловсруулан бэлтгэж тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах” гэсэн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд иргэдийн санал авч эрэмблэгдсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг батлах, батлагдсан төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах.

3.1.4 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2012-2019 онуудад 7 иргэнтэй холбоотой гэрээний хугацаа дууссан зээлүүд төлөгдөөгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар” Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 10 дугаар зүйлийн 10.1-д “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээлүүдийг төлүүлэх ажил зохион байгуулан ажиллаж, төлөгдөхгүй тохиолдолд хуулийн дагуу дараагийн шатны байгууллага албан тушаалтанд шилжүүлэн ажиллах.

3.1.5 Төрийн сан дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зэрэг Шим Ус ОНӨААТҮГ-ийн төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд хамаарахгүй албан тушаалтнуудад орон нутгийн нэмэгдэл тооцон олгосон, эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн, ОНӨААТҮГ-т хамааралгүй цалингийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт 2.1. “Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, сар бүр олгоно”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10-д “Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн хяналтыг сайжруулах, хууль журам зөрчсөн гүйлгээг гаргахгүй байх, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд онцгой анхаарах.

3.1.6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Зэрэг Шим-Ус ОНӨААТҮГ нь Шилэн дансны нэгдсэн цахим системд өөрийн байгууллагын цэсийг нээж мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлээгүй. Шилэн дансны тухай хуулийн 3.1.1. “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд”, 4.1.4. “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, өөрийн байгууллагын цэсийг нээлгүүлж хуулийн дагуу мэдээлэгдэх бүх мэдээллийг нээлттэй ил тод мэдээлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ОНХС	Санхүүгийн тайланд орлого зарлагыг зөрүүтэй тусгасан	1	34,186.8			1	34,186.8	1	34,186.8				
	Чанарын баталгааны үлдэгдлийг өр төлбөрт тусгаагүй	1	2,126.0	1	2,126.0			1	2,126.0				
ХХС	Хүүгийн авлага зөрүүтэй илэрхийлсэн	1	2,017.1			1	2,017.1	1	2,017.1				
ДҮН		3	38,329.9	1	2,126.0	2	36,203.9	3	38,329.9		0	0	0

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ОНХС	ТАХ-ний жагсаалтад ороогүй ажилд хөрөнгө зарцуулсан	1	7,877.8					1	7,877.8		
	Төлбөрийн харьцааг 70/30 хувиар хийж урьдчилгаа төлбөр олгосон. Гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй	1	104,422.2					1	104,422.2		
	Хөтөлбөр арга хэмжээний зардлыг бөөн дүнгээр баталсан. 1 хөтөлбөрийн 85 хувийг бөхийн тэмцээнд зарцуулсан.	1	35,000.0					1	35,000.0		

Зэрэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ХХС	Хугацаа дууссан зээлүүд төлөгдөөгүй	1	28,800.1					1	28,800.1		
Зэрэг Шим-Ус ОНӨААТҮГ	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд хамаарахгүй албан тушаалтнуудад орон нутгийн нэмэгдэл тооцон олгосон	1	5,083.6					1	5,083.6		
Нийт дүн		5	181,183.7			0	0	5	181,183.7	0	0

4.3 Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны нэгдсэн цахим системд Зэрэг Шим-Ус ОНӨААТҮГ нь өөрийн байгууллагын цэсийг нээж мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлээгүй.	1	-					1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТТЗ	1	1				1			
	НИЙТ	1	1				1			